

Та Брандэнбүргийн дээд сургуулийн интернет хуудаст тавтай морилно уу. Манай дээд сургуулийн тухай мэдээлэлийг сонирхож байгаад бид маш их баяртай байна.

Брандэнбүрг дээд сургууль нь олон улсын дээд сургууль болон өргөжиж байгаа дээд сургуулиудын нэг юм. Тус сургууль нь бүх мэргэжлийн сургалтаа олон улсын түвшний Бакалавр, Мастерийн зэрэгтэй төгсгөх мөн сургалтаа удахгүй англи хэл дээр явуулах болно. Манай сургуульд дэлхийн 40 гаруй орны оюутнууд ирж суралцаж байгаад бид их сэтгэл хангалуун байдаг. Цаашид улам олон гадаадын оюутнуудыг өөрийн сургуульд элсүүлэн суралцуулах сонирхолтой байгаа учраас манай сургуулийг зоригсдийг бид сэтгэл хангалуун угтана.

Та манай сургуулийн тухай мэдээлэлийг өөрийн төрөлх хэл дээр уншихийг хүсвэл энэ цонхыг идэвхижүүлнэ үү:

Хэрэв та буцаад эхний хуудаст очих ба манай сургуульд суралцах мэргэжлийн чиглэлийн талаар мэдээлэлийг англи хэл дээр (герман хэл дээр) уншихийг хүсвэл энэ цонхыг идэвхижүүлнэ үү:

#### 1. Зах зээлийн мэргэжлийн сургалт бүхий залуу дээд сургууль

1992 оны 4 дүгээр сард анх Хавэл мөрний эрэг дээрх Брандэнбүрг хотод Брандэнбүргийн дээд сургууль байгуулагдсанаар энэ хот өөрийн 1000-аас дээш жилийн түүхэндээ анх удаа дээд сургуультай хот болсон билээ. 1997 он хүртэл эртний тусгай хамгаалалтын морин цэргийн казэгн байсан байрыг сэргээн засварлан, шинээр тохижуулсан байранд Брандэнбүргийн дээд сургуулийн хичээлийн байрууд байгуулагдсан билээ. Тус сургууль нь техник, эдийн засаг, информатик ба мэдээлэл зүй гэсэн гурван тэнхимүүдэд орчин үеийн шаардлагад тохирсон мэргэжлийн ангидийг санал болгож байна.

Ногоон цэцэрлэгт хүрээлэн мэт орчинтой байгууламжинд орчин үеийн лабораторууд ба анги тэнхимүүдэд 2500 –аас дээш залуучууд суралцаж байна. Тус сургуулийн санал болгож буй мэргэжлийн чиглэлүүдийн тоо жил ирэх тутамд нэмэгдэж байгаа бөгөөд түүний хажуугаар олон улсын зэрэглэлийн Бакалавр, Мастерийн төгсөлттэй ангиуд нэмэгдэж байгаа, жишээлбэл информатикч ба мэдээлэл зүйч, технологийн ба инновацион менежмент. Брандэнбүрг дээд сургуулийн оюутнууд төсөл дээр хамтран ажиллах сургалтын чиглэлийг илүүд үздэг. Төслийн ажлын сэдвийг тус орон нутгийн эдийн засаг, аж үйлдвэрийн газрууд, засаг захиргааны байгууллагууд хамтран шийдвэрлэдэг. Энэ нь оюутнуудийг ирээдүйн мэргэжлийн салбартаа ажиллах дадлага туршлага, ажлын байртайгаа танилцах боломжийг олгодог давуу талтай юм. Ялангуяа манай дээд сургууль нь олон улсын солилцооны шинжилгээ судалгаа, сургалтын саналыг дэмжин хамтран ажилладаг юм. Брандэнбүрг дээд сургууль нь европийн болон далайн чанадын орнуудын их дээд сургуулиудтай харилцаа холбоотой ажилладаг.

Сургуулийн төв байр болох 1881 онд баригдсан хааны тусгай хамгаалалтын морин цэргийн байранд өнөөдөр сургуулийн удирдлага ба эдийн засгийн ухааны тэнхим байрладаг. Тэр үеийн морины хашаа байсан газар өнөөдөр орчин үеийн тоног төхөөрөмж бүхий номын сан, офицерүүдийн байрлаж байсан байранд өнөөдөр лекц уншлагын байр байрлаж байна. Эдгээр улаан тоосгоор баригдсан эртний барилгууд, шинээр баригдсан шаргал өнгийн шатаасан тоосгоор баригдсан гурван барилга хоорондоо зохицон Брандэнбүргийн дээд

сургуулийн хичээлийн байруудыг үнэхээр Герман улс дахь сайхан газруудын нэг гэдгийг тодотгодог.

## 2. Ямар мэргэжлээр Брандэнбүргийн дээд сургуульд суралцах боломжтой бэ?

Тэнхим	Мэргэжлийн чиглэл	Голлон үзэх мэргэшил	Төгсөлт	Элсэгчийн тоо хязгаартай эсэх
Эдийн засаг	Бизнес судлал эдийн засагч	- Инновацион менежмент - Олон улсын менежмент - Жижиг дунд үйлдвэрийн газрын бизнес судлаач эдийн засагч	Диплом -Бизнес судлаач эдийн засагч	тийм
	Эдийн засагч информатикч	- Хамтын ажиллагааны тогтолцооны мэдээлэлийн менежмент - Үйлдвэрийн хэрэглээний нэгдсэн систем - Маркетинг ба дигитал медиен менежмент	Диплом – эдийн засагч информатикч	тийм
	Технологийн ба инновацион менежмент		Мастер	үгүй
Информатик ба медиен	Информатик	- Боловсронгуй систем - Сүлжээ тооцоолон бодолт - Дигитал медиен	Бакалавр	үгүй
	Информатик	- Мэдээлэлийн хэрэглээ, үйл ажиллагааны систем - Сүлжээ буюу хөдөлгөөнт сүлжээн тооцоолон бодолт - Дигитал медиен	Мастер	үгүй
	Онлайн сургалт – Медиен информатик		Бакалавр, Мастер	тийм
	Тооцоолон бодолт ба информатик	- Программ хангамж - Цогцолбор систем боловруулалт	Бакалавр	тийм
Техник	Инженер	- Электрон ба мэдээлэлийн техник - Машин механизм - Физик техник	Диплом – инженер	үгүй
	Мехатроник		Бакалавр инженер	үгүй
	Фотоник	- Гэрэл зүйн технологич - Гэрэл зүйн багаж төхөөрөмж	Мастер инженер	үгүй

## 3. Олон улсын мастерийн сургалт: Технологийн ба инновацион менежмент (ТИМ)

Брандэнбүргийн дээд сургууль Коттбус хотын Брандэнбүргийн техникийн их сургуультай хамтран мэргэжил дээшлүүлэх журмаар олон улсын сургалтын мастерийн ангийг технологийн ба инновацион менежмент мэргэжлээр төгсгөдөг. ТИМ –ийн сургалтын гол зорилго нь техник, эдийн засгийн ухааны хоорондын уялдаа холбоог гүнзгийрүүлэн судлах явдал юм. Энэ сургалтанд хамрагдахыг хүсэгч нь 4 жилийн их дээд сургууль төгссөн инженер, байгалийн шинжлэх ухаан эсвэл мэдээлэл зүйч мэргэжилтэй байх шаардлагатай. Мөн 1 жил ажилласан байх шаардлагатайгаас гадна англи, герман хэлний зохих мэдлэгтэй байх ёстой бөгөөд түүнийгээ бичгээр баталгаажуулсан баримттай байх ёстой.

Нийт 4 улирал өөрөөр хэлбэл хоёр жил суралцсаны эцэст Мастерийн зэрэгтэй төгсөнө. Энэ эрдмийн зэрэг нь олон улсын түвшинд хүлээн зөвшөөрөгдсөн байдаг учраас гадаадын олон орны оюутнууд энэ сургалтанд хамрагдах сонирхолтой байдаг.

Гадаад орны суралцахыг сонирхогчид германий оюутнуудын солилцооны холбоонд (ДААД-д) тэтгэмжийн талаар хандаж болно. Хэрвээ та тэтгэмжинд хамрагдвал үндсэн сургалт эхлэхээс өмнө хагас жилийн хэлний курс хийх эрх энэ тэтгэмжинд хамрагдана. Хичээлийн явагдах хэлбэр нь лекц, семинар, дадлага, лабороторийн ажил, практик, төслийн ажил, оюутны зөвлөгөө зэрэг хэлбэрээр явагдахаас гадна зарим төрлийн хичээлүүд герман хэлээс гадна англи хэл дээр явагдана.

ТИМ 5 төрлийн чиг баримжаа бүхий хичээлүүдээс бүрдэнэ. Эдгээр нь Брандэнбург ба Коттбус хотуудад заагдана.

- Менежментийн үндэс
- Технологийн ба инновацион менежмент
- Инженерийн менежмент ба гүнзгийрүүлсэн техник
- Төслийн үндэс
- Нийгмийн хариуцлага

#### 4. Европийн сургалтын үнэлгээний систем

Европийн сургалтын үнэлгээний систем гэж юу юм бэ?

Энэ нь европийн комиссоос хүлээн зөвшөөрөгдсөн сургалтын үнэлгээний систем юм.

Европийн сургалтын үнэлгээний системийн кредит оноо

Кредит үнэлгээний систем нь оюутны бүх л суралцах хугацааны туршид гаргасан идэвхи чармайлтыг үнэлдэгээрээ давуу талтай. Жишээлбэл: Лекцинд оролцсон байдал, дадлага семинарын идэвхи, өөрийн идэвхи зүтгэл мөн шалгалтын үр дүн гэх мэт бүх чармайлт тооцогддог.

Өдрийн оюутан буюу үндсэн оюутан нийт суралцах хугацааныхаа туршид 60 кредит оноо, гэхдээ хичээлийн улирал тутамд 30 оноо авсан байх ёстой. Кредит оноог зөвхөн бүх лекц семинарт оролцсон бөгөөд шалгалтуудаа амжилттай өгсөн тохиолдолд авна.

Кредит онооны үнэлгээний зарчим

Кредит оноо	Оюутны авбал зохих оноо, хувиар	Тодорхойлолт
A	10	Онцсайн: маш бага зэргийн алдаатай амжилт
B	25	Онц: дундаж түвшнээс дээш, бага зэргийн алдаатай
C	30	Сайн: хэд хэдэн алдаатай ерөнхийдөө сайн
D	25	Хангалттай: хангалттай, мэлээн алдаатай
E	10	Хүрэлцэхүйц: хамгийн доод авбал зохих оноо
FX		Тэнцэхгүй: үнэлгээ авахаас өмнө биеэ дайчлах хэрэгтэй
F		Тэнцэхгүй: мэдэгдэхүйц, хурдан суралцах арга барилаа сайжруулах хэрэгтэй

Кредит оноонд шилжүүлэх

Хэрвээ манай сургуульд суралцахыг хүсэгч өөрийн төрсөн оронд их дээд сургууль төгссөн бол түүнийгээ кредит үнэлгээнд шилжүүлэн хүлээн зөвшөөрүүлэн цаг алдалгүй цаашаа суралцаж болно.

Тодорхой мэдээлэлийг та сургуулийн интернет хуудас дахь тэнхмүүдийн мэдээлэлээс харна уу.

## 5. Брандэнбүргийн дээд сургуульд үндсэн оюутнаар суралцах 5.1 Суралцах эрх авах

Брандэнбүргийн дээд сургууль нь сургалтын төлбөргүй. Элсэлт зөвхөн өвлийн хичээлийн улиралд боломжтой. 9 сарын 30-нд эхлэх хичээлийн жилийн элсэлтийн өргөдөл хүлээн авах сүүлийн хугацаа 6 сарын 30. Бид таньд зөвлөхөд энэ хугацаанаас 4 долоо хоногийн өмнө таны өргөдөл манай сургуульд ирсэн байхаар явуулаарай. Учир нь өргөдөл хүлээн авах, таны мэдээлэлийг шалгах ажиллагаа нь цаг их шаардлагатай байдаг бөгөөд энэ нь UNI ASSIST гэдэг байгууллагаар дамжин явагддаг учраас тодорхой хугацаа тооцоолж явуулаарай. Ингэснээр таны бүрдүүлэх ёстой баримт бичгээс ямар нэгэн баримт дутуу тохиолдолд цаг хугацаанд нь дахин манай сургуульруу илгээх боломжийг таньд олгох юм. Зөвхөн бүрэн гүйцэт материал бүхий өргөдөл л Брандэнбүргийн дээд сургуульруу дамжуулагдана.

2004 оны 3 сарын 1-нээс эхлэн бүх диплом, бакалаврийн сургалтанд хамрагдагсдын өргөдөл хангалттай эсэх, бүрэн гүйцэт эсэхийг UNI ASSIST гэдэг байгууллагаар шалгагддаг болсон. Үүнтэй холбоотой мэдээлэлийг та [www.uni-assist.de](http://www.uni-assist.de) гэсэн хаягаар орон уншиж болно. Та өөрийн өргөдлийг дагалдах материалын хамт доорхи хаягаар явуулаарай:

Fachhochschule Brandenburg  
c/o UNI-ASSIST e.V.  
Helmholzstr. 2-9  
10587 Berlin

Хэрвээ таны хувийн хэрэг материал үнэн зөв, шаардлага хангасан тохиолдолд UNI ASSIST таны материалыг Брандэнбүргийн дээд сургуульруу илгээнэ. Таньд элсэлтийн эрх олгох эсэхийг Брандэнбүргийн дээд сургууль өөрөө шийдвэрлэнэ. UNI ASSIST –ийн материал хүлээн авах шалгах ажиллагаа тодорхой төлбөртэй.

Мастерийн сургалтанд хамрагсад сургуульд элсэх өргөдөл, материалаа шууд Брандэнбүргийн дээд сургуульруу илгээгээрэй. UNI ASSIST байгууллагаар дамжуулах шаардлагагүй.

Өргөдөл явуулахдаа доор дурдсан материалуудыг герман эсвэл англи хэлээр орчуулсан орчуулгын хувийг баталгаажуулсан тэмдэгтэй илгээнэ үү:

- Гадаадын оюутнуудад зориулсан өргөдөл (сургуулийн интернет хуудаст байгаа)
- Ерөнхий боловсролийн сургууль төгссөн гэрчилгээ бүх хичээлийн нэр, дүнтэй хамт
- Боломжтой бол: дээд сургуульд орох шалгалтанд орсон бичиг
- Боломжтой бол: дээд сургуульд суралцсан дүнгийн жагсаалт
- Боломжтой бол: дээд сургуульд тэнцсэн гэрчилгээ
- Хэлний мэдлэгийг баталгаажуулсан бичиг

- Мастерийн сургалтанд хамрагдагсад англи хэлний мэдлэгийг баталгаажуулсан бичиг, ажлын газрын тодорхойлолт

Брандэнбүргийн дээд сургуульд бүртгүүлэхээр ирэхдээ авчирах бичиг баримт:

- Хүчинтэй суралцах визтэй гадаад паспорт
- Герман улсын эрүүл мэндийн даатгалын гэрчилгээ
- Улиралын төлбөрийг төлсөн мөнгөний баримт

Герман хэлний мэдлэгийн түвшин

Брандэнбүргийн дээд сургуульд суралцахыг хүсэгчид тодорхой хэмжээний герман хэлний мэдлэгтэй байх ёстой бөгөөд доорхи шалгалтуудын аль нэгийг өгсөн байх шаардлагатай:

- DSH шалгалт [www.fadag.de/pruef/](http://www.fadag.de/pruef/)
- Тэст Daf [www.testdaf.de](http://www.testdaf.de)
- Гоэтэ институтийн герман хэлний жижиг болон том диплом [www.goethe.de/dll/prf/deindex.htm](http://www.goethe.de/dll/prf/deindex.htm)
- Гоэтэ институтийн дунд болон дээд түвшний шалгалтанд тэнцсэн
- Хэлний курсын 2- р түвшний шалгалт

Эдгээр гэрчилгээг манай сургууль шаардах ба хэрвээ хэлнийхээ шалгалтаа эхний хичээлийн улиралд багтаан өгч амжихгүй бол сургуулиас хасна. Брандэнбүргийн дээд сургууль өөрөө хэлний ямарч курс байхгүй.

## 5.2 Герман улсад зорьчих буюу суралцах виз авах журам

Брандэнбүргийн дээд сургуульд элсэн орохын тулд та юуны өмнө оюутны виз авсан байх хэрэгтэй. Визний өргөдөл хүлээн авах болон тухайн өргөдлийг шийдвэрлэж хариу өгөх ажиллагаа харилцан адилгүй байдаг учраас та хүссэн хугацаанаасаа хэдэн сарын өмнө өргөдлөө өгөхийг анхааруулая.

Суралцах виз авах тухай сүүлийн үеийн мэдээлэлийг та интернетд [www.auswaertigesamt.de/www/de/willkommen/einreisebestimmungen/index\\_html](http://www.auswaertigesamt.de/www/de/willkommen/einreisebestimmungen/index_html) хаягаас уншиж болно.

Анхаарах зүйл: Суралцахын тулд виз авахдаа зөвхөн суралцах эрхтэй виз авахыг анхааруулая. Жуулчин буюу аялалын визээр суралцах эрхгүй. Жуулчны виз герман улсад ирсний дараа өөрчлөх боломжгүй байдаг. Тиймээс та зөвхөн суралцах эрхтэй виз аваарай.

## 5.3 Суралцах хугацаанд байрлах байр

Оюутны байр

Брандэнбүрг хотод дээд сургуулиасаа холгүй орших оюутны байр байдаг. Оюутны байранд орох өргөдлийг та манай сургуульд орох эрхийн бичигтэй хамт хүлээн авах болно.

Оюутны байртай холбогдсон мэдээлэлийг та интернетд <http://www.studentenwerk-potsdam.de/wohnen.html> хаягаар уншиж болно. Оюутны асуудал хариуцсан байгууллагаас та оюутны байранд орох эрхийн бичиг авна. Оюутны асуудал хариуцсан байгууллага нь Потсдам хотод байралдаг бөгөөд хувиараа байр болон өрөө олоход бас жуулчилдаг. Хаяг нь:

Studentenwerk Potsdam

Abteilung Studentisches Wohnen  
Friedrich-Ebert-Str. 4  
14467 Potsdam

Хувиараа байр хөлслөх

Хэрвээ та оюутны байранд сул өрөө авч чадаагүй бол эсвэл та өөрөө оюутны байранд амьдрах хүсэлгүй бол оюутны асуудал хариуцсан байгууллага таньд хувь хүмүүсийн байрыг хөлслөхөд жуулчлана. Мөн сургуулийн оюутны зөвлөлийн нийгмийн асуудал хариуцсан оюутан-ажилтан байр олоход тань туслана. Эмайл хаяг: [astasoZIAles@fh-brandenburg.de](mailto:astasoZIAles@fh-brandenburg.de)

Сургуулиас 15 минут яваад очих газарт “Caasi” хэмээх хөлсний байрууд байралдаг. “Caasi” нь хэсэг хугацаанд байр олтлоо хоноглох боломжийг олгодог бөгөөд нэг буюу хоёр өрөө байруудыг оюутнуудад хөнгөлөлттэй үнээр хөлслүүлдэг. Эдгээр өрөөнүүд нь гал тогоо, 00 өрөө буюу шүршүүр бүхий өрөөтэй. Тодорхой мэдээлэлийг та интернетд [www.caasi.de](http://www.caasi.de) хаягаар орж үзэх болон асуух зүйлээ асуух буюу захиалга өгч болно.

6. Герман улсад ирсний дараах бичиг баримтын бүрдүүлэлт

Герман улсад ирсний дараа та нэг долоо хоногын дотор Брандэнбург хотын иргэний бүртгэл мэдээлэлийн албанд бүртгүүлэх ёстой. Бүртгэлийн алба нь Am Gallberg 4B гудамжинд орших бөгөөд утасны дугаар: 03381 581351

Хэрвээ та Брандэнбург хот дотроо нүүх бол бүртгэлийн албанд бас бүртгүүлэх ёстой. Хэрвээ Брандэнбург хотоос өөр хотод амьдрах бол амьдрах хотынхоо бүртгэлийн албанд бүртгүүлнэ.

Бүртгэлийн албанд бүртгүүлэхдээ авчиргах бичиг баримт:

- Гадаад паспорт
- Байрны гэрээ

Сургуулийн гадаад оюутны асуудал хариуцсан алба та бүхэнд дуртай туслана. Хичээлийн шинэ жил эхлэхээс өмнө тодорхой хугацаа тогтоон хамтдаа бичиг баримт бөглөхөд туслана.

Эрүүл мэндийн даатгал

Герман улсын их дээд сургуульд элсэгчид герман улсын хуулийн дагуу эрүүл мэндийн даатгалд хамрагдах ёстой. Зарим тодорхой нэгэн шалтгааны улмаас хувийн эрүүл мэндийн даатгалд хамарч болно. Энэ нь та өвчлөх тохиолдолд хязгаарлагдмал нөхцөлийг хангана.

Герман улсад оршин суух эрх

Бүх герман улсад суралцдаг гадаадын оюутнууд герман улсад оршин суух эрх авах шаардлагатай. Оршин суух эрхийг хугацаа дуусахаас өмнөхөн гадаадын иргэдийн асууцал хариуцсан газар сунгуулна.

Гадаадын иргэдийн асуудал хариуцсан газрын хаяг:

Watschauer str. 7  
14472 Brandenburg (03381 72590)

Иргэдийг хүлээн авах цагийн хуваарь:

Мягмар гариг: 7:30 – 12:00 ба 13:00 – 18:00

Пүрэв гариг:

7:30 – 12:00 ба 13:00 – 15:00

Шаардлагатай материал:

- Гүйцэт бөглөсөн виз сунгуулах өргөдөл
- Хүчин төгөлдөр гадаад паспорт
- Виз, шаардлагатай нөхцөлд
- Нэг ширхэг паспортийн зураг
- Сургуульд суралцах эрхийн бичиг
- Эрүүл мэндийн даатгалын гэрчилгээ (герман улсын хуулийн дагуу эрүүл мэндийн даатгал)
- Иргэний бүртгэлийн газар бүртгүүлсэн бичиг (Герман улсын иргэний бүртгэл мэдээлэлийн төвд бүртгүүлэхэд өгнө)
- Амьжиргааны түвшний баталгаат санхүүжилтийн тодорхойлолт (жишээ нь: өөрийн дансан дахь мөнгө эсвэл тодорхой нэгэн батлан даагчийн баталгаат бичиг)

7. Брандэнбүргийн дээд сургуулийн ерөнхий мэдээлэл

Автобус унааны билет

Сургуульд элсэгч бүр хичээлийн шинэ жилд Брандэнбург, Берлин хотод зорчих эрх бүхий унааны билет авна.

Оюутны хоолны газар ба зуушны газар

Сургуулийн хичээлийн байрнаас холгүй орших хоолны газар, зуушны газар нь даваа гаригаас баасан гариг хүртэл нийтэд үйлчилнэ. Зуушны газар өглөө 8 цагаас онгойх бөгөөд өглөөний цай болон зуушаар үйлчилнэ. Өдрийн хоолыг 11 цагаас 14 цагын хооронд хоолны газар идэх боломжтой. Энд өдөр бүр 4 өөр төрлийн хоол сонгох боломжтой, үнэ нь 1,20 еврогоос 2,30 евроны хооронд байдаг.

Урлаг спорт

Сургуулийн оюутны зөвлөл олон төрлийн спортын төрлөөр хичээллэх боломж олгодог. Жишээлбэл: Волейбол, хөл бөмбөг, усан спорт.

Эдийн засгийн тэнхмийн доор оюутны бар "IQ" янз бүрийн урлаг уран сайхны ажиллагаа явуулдаг.

Эмайл хаягын эрх

Манай сургуульд суралцагч бүр өөрийг гэсэн эмайл хаяг мөн өөрийн гэсэн мэдээлэл хадгалах сан бүхий эрх авна. Zanderstr. гудамжинд байдаг оюутны байрнаас интернетд орох боломжтой.

Номын сан

Номын сан нь маш том уншлагын заалтай ба номын сангийн номын мэдээлэлийг мөн хүссэн номоо интернетээр хайх боломжтой. Интернет хаяг:

[www.fh-brandenburg.de/bibliothek/www.htm](http://www.fh-brandenburg.de/bibliothek/www.htm)

Номын санд эхлэж үйлчлүүлэхдээ та оюутны үнэмлэхээ үзүүлэх шаардлагатай.

Үйлчилгээ, туслалцаа

Сургуулийн гадаад оюутнуудыг хариуцсан алба хичээлийн эхний хугацаанд гадаад оюутнуудад зориулсан мэдээлэл өгөх үйл ажиллагаа зохион байгуулдаг. Мөн оюутан туслагч та бүхэнд хичээлийн хувиараа харах, ойролцоох хүнсний дэлгүүрээ олох гэх мэтийн жижиг сажиг зүйлсд туслахад бэлэн байдаг.

Хичээлийн жил

Хичээлийн шинэ жил шинээр элсэгч оюутнуудын хувьд нэг долоо хоногын өмнө удиртгал буюу сургууль орчинтойгоо танилцах долоо хоногоор эхлэнэ. Энэ нь

ихэвчлэн ёс дүгээр сарын дундуур эхлэдэг. Өвлийн хичээлийн жилийн лекцийн үргэлжлэх цаг 9 сарын дундаас 1 сарын сүүл хүртэл, шалгалтын үргэлжлэх хугацаа 2 сарын дунд хүртэл. Зуны хичээлийн жил 3 сарын дундаас 6 сарын сүүл хүртэл үргэлжлэнэ. Шалгалт 7 сарын дунд хүртэл үргэлжлэнэ.

Зарим нэгэн туслалцаа дэмжлэг

Брандэнбург хотын амьдрах амьжиргааны өртөг сарын 500- 600 евро. Манай дээд сургууль өөрөө стипент буюу ямар нэгэн оюутны цалин өгдөггүй. Гэхдээ герман улсад суралцагчидад зориулсан ямар нэгэн сангийн тусламжтайгаар стипенттэй суралцах боломжтой. Дэлгэрэнгүй мэдээлэлийг доорхи интернет хаягаас мэдэж болно. [www.daad.de/deutschland/de.2.4.7.html](http://www.daad.de/deutschland/de.2.4.7.html)

8. Брандэнбург хот дахь амьдрал

1050 жилийн түүхтэй Хавэл мөрний эрэг дээрхи Брандэнбург хот нь түүхийн 3 хэсэгтэй: хуучин хот, шинэ хот ба Дом арал. Хавэл мөрөн шинэ хуучин хоёр хотыг таллан урсдаг. Хот болгон хоёр том хаалгатай цамхаг, далан бүхий эртний хотын хашааны үлдэгдэл энэ бүгд эртний хотын уран барилга ба бэхлэлтийг санагдуулна.

Шинэ хотод байдаг 1401 онд баригдсан уран барилгын аргаар тоосгоор баригдсан Санкт Катеринэн сүмийн барилга оршдог. Хуучин хотод үүнээс хэдхэн жилийн дараа бас тоосгоор баригдсан Санкт Готтхардийн сүм бий. Хотын захиргааны барилгын өмнө жижиг Роландийн чулуун хөшөө бий. Энэ 5 метр өндөр бүхий бүтээл 15 дугаар зууны сүүлээр Брандэнбург хотын таних тэмдэг байжээ.

Хуучны хотын төв байсан Дом арал дээр Брандэнбургийн хамгийн эртний барилга болох Санкт Петер ба Паулын цогчин дуган оршдог. Энэ барилга нь 1165 онд ромын уран барилгын аргаар эхлэж баригдаад сонгодог аргаар баригдаж дууссан билээ. Брандэнбург хот нь 400 гаруй эртний дурсгалт хөшөө барилгатайгаараа муж дотроо хамгийн их эртний хөшөө дурсгалт зүйлийг авч үлдсэн хот гэж тодорхойлогддог юм. Эдгээр эртний түүхийн дурсгалт зүйлийн бараг тал хувь нь дахин сэргээн засварлагдсан.

Брандэнбург хотын дүр зургыг Хавэл мөрнөөр тодорхойлж болно. Энэ хотын ой модоор дүүрэн, ногоон цэцэрлэг бүхий байгаль мөн олон тооны жижиг нуурууд нь спортын тэмцээн явуулах болон амралт чөлөөт цагаа өнгөрөөхөд боломжтой газар юм. Үнэнийг хэлэхэд өвлийн улиралд тийм ч их боломж олгохгүй ч хөлдсөн нууран дээр чаргаар гулгах, Магиенбэрг ууланд цанаар гулгах боломжтой.

Дулаан улиралд янз бүрийн арга хэмжээ явуулах жишээлбэл: далбаат усан онгоцоор явах, моторт онгоцоор явах, сэлүүрт завиар явах, усанд сэлэх, загасчлах гээд. Брандэнбург хот нь усан спортынхныг өөртөө татахаас гадна явган аялагч, дугуйгаар аялагчдыг нарийн замчилж газарчилсан замын тэмдэг бүхий замаар аялах боломжийг олгодог. Морин спорт, нислэгийн спортынхон, гольф тоглогчид бас энд ирэх дуртай байдаг.

Хавэл мөрний эрэг дээрхи Брандэнбург хот нь өөрийн муж улс Брандэнбург нэрээр нэрлэгддэгийг бас Германы олон хүмүүс мэддэггүй.

Брандэнбург хотын олон нийтийн газрууд

Брандэнбург хотод олон төрлийн сонирхолтой музей бий. Жишээлбэл: аж үйлдвэрийн музей, энх тайвны манаа буюу “доктор Моттэсийн эгшигт цамхаг”, Дом музей, эрүүгийн хэргийн музей, нисэх онгоцны үзэсгэлэн музей гэх мэт олон төрлийн музей бий.

Энэ хотод мөн унадаг дугуй, завь, далбаат усан онгоц зээлээр түрээслүүлэх үйлчилгээтэй газрууд олон бий. Хүмүүсийн дуртай зүйлийн нэг бол усан онгоцоор Хавэлийг тойрон аялах юм. Мөн бассейн, театр, хоёр кинотеатр, дискотэк бий.

Брандэнбург хотын талаарх бусад мэдээлэлийг доорхи хаягаар орон үзэж болно:

[www.fvv-brandenburg.de](http://www.fvv-brandenburg.de)

[www.stadt-brb.de](http://www.stadt-brb.de)